



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/241

Булган сум

Классик пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дорноговь аймагт 2026 оны 03 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах Классик пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох 5 тамирчин, 1 дасгалжуулагчийн байр, унааны зардалд 1,620,000 (нэг сая зургаан зуун хорин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010316